



ГАЙМАГ, ДҮҮРЭГ (НИЙСЛЭЛ)-ИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС
(ГАЗАР)-ИЙН ДАРГА НАРТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Хуульчдын гудамж 13/1, Утас: 32-80-30, Факс: (976-11) 32-07-16
E-mail:undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2014 . 07 . 24 № 1/1190.

танай _____ -ны № _____ -т

Г Аргачлал хүргүүлэх тухай

Батлан хамгаалах яамны төрийн нарийн бичгийн дарга, тус газрын даргын хамтарсан тушаалаар батлагдсан “Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах аргачлал”-ыг хүргүүлэв. Аргачлалыг хэрэгжүүлэхдээ дараах асуудлуудыг анхаарч ажиллавал зохино. Үүнд:

1. Аргачлал батлагдсантай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2010 оны 1/891, 2011 оны 1/1110, 2012 оны 1/1330 дугаар албан тоотоор хүргүүлсэн аргачлал, чиглэлийг 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүйд тооцно.

2. Аргачлал хүргүүлэх тухай 2010 оны 1/891 дүгээр албан тоотын 1-д дурдсаныг үндэслэн “Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай” хуулийн дагуу хөдөлмөрийн чадвар алдсаны болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох өргөдөл (материал)-ийг 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүлээн авахгүй, тэтгэвэр тогтоохгүй.

3. Цэргийн байгууллагад ажиллаж байгаад ажлаас гарсан, улмаар ажил хөдөлмөр эрхлээгүй (ажилгүй) байхдаа тахир дутуу болсон иргэдийн асуудлыг шийдвэрлэхдээ дараах чиглэл баримталж ажиллана. Үүнд:


а/ “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-д заасан болзол, нөхцлийг хангаж буй иргэдэд тахир дутуугийн тэтгэврийг хуулийн дагуу тогтоон олгоходоо 1995 оноос өмнө байлдагч, түрүүчээр цэргийн алба хааснаас бусад цэргийн алба хаасан хугацааг иргэний байгууллагад ажиллан шимтгэл төлсөн хугацаанд шилжүүлэн тооцохгүй;

б/ “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-д заасан болзол, нөхцлийг хангаагүй иргэдийг Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу нийгмийн халамжийн тэтгэвэр тогтоолгохоор шилжүүлэх арга хэмжээ авах;

в/ “Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хууль”-ийн дагуу 1990-2000 оны хооронд ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцуулах боломжтой иргэдийг холбогдох журам, аргачлал, чиглэлийн дагуу бүртгэж, 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөх бэлтгэл хангах;

4. Мөн цэргийн байгууллагад ажиллаж байгаад ажлаас гарсан, улмаар ажил хөдөлмөр эрхлээгүй (ажилгүй) байхдаа нас барсан иргэдийн хувьд зөвхөн “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-д заасан болзол, нөхцлийг хангаж буй бол гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдэд тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоон олгоходоо цэргийн алба хаасан хугацааг иргэний байгууллагад ажиллан шимтгэл төлсөн хугацаанд шилжүүлэн тооцохгүй (зөвхөн 1995 оноос өмнө байлдагч, түрүүчээр цэргийн алба хаасан хугацааг иргэний байгууллагад ажилласнаар шилжүүлнэ) зэрэг болно.

Хавсралт 8 хуудастай.

ДАРГА  Ц.УРТНАСАН

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2014 оны 07 дугаар
сарын 22.-ны өдөр

№ А/58:
№ А/105

Улаанбаатар хот

Аргачлал батлах тухай

Монгол Улсын "Яамны эрх зүйн байдлын тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.1 дэх заалт, "Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай" хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2, 8.4 дэх хэсэг, "Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай" хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, Засгийн газрын 1994 оны 171 дүгээр тогтоолоор баталсан "Нийгмийн даатгалын байгууллага, байцаагчийн дүрэм"-ийн "Гурав"-ын 16-гийн "к" заалт, Цэргийн албан хаагчийн тэтгэврийг тогтоох, олгох ажлын талаар Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар, Батлан хамгаалах яамны хооронд 1999 онд байгуулсан гэрээг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. "Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай" хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах аргачлал"-ыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Батлагдсан аргачлалыг хэрэгжүүлж ажиллахыг Батлан хамгаалах яамны Төрийн Захиргааны удирдлагын газар (хур.Д.Мөнх-Очир)-т, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийн газар (Б.Батбаатар)-т тус тус үүрэг болгосугай.

Гурав. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Батлан хамгаалах яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар (хур.Т.Лодойдамба)-т, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газар (Н.Ариунаа)-т тус тус даалгасугай.

Дөрөв. Энэ тушаалыг 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ХОШУУЧ ТЕНЕРАЛ

З.БОЛДБААТАР

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,
НИЙГМИЙН ДААТГАЛЫН УЛСЫН
ЕРӨНХИЙ БАЙЦААГЧ

Ц.УРТНАСАН

Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга,
Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2014 оны
хамтарсан А/105... дугаар тушаалтын хавсралт
А/58,

ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ АРГАЧЛАЛ

1. Хугацаат цэргийн албыг 1995 оноос өмнө байлдагч, түрүүчээр хаасан бол 1 жилийг нь 1 жил 6 сараар нэмэгдүүлэн тооцох тухайд:

“Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль” хэрэгжиж эхэлсэн хугацаанаас хойш буюу 2010 оны 09 дүгээр сарын 16-ны өдрөөс хойш зөвхөн шинээр өндөр насны тэтгэврээ тогтоолгох иргэний хувьд түүний хугацаат цэргийн алба хаасан 1 жилийг 1 жил 6 сараар иргэний байгууллагад ажилласнаар шилжүүлэн тооцно.

“Зэвсэгт хүчний тухай хууль”-ийн 18 дугаар зүйлийн 18.2.9 дэх заалтын дагуу цэргийн албаа үлгэр жишээчээр хааж, хугацаа дуусахаас өмнө халагдсан цэргийн зохих мэргэжил эзэмшсэн байлдагч, түрүүчийг тухайн цаг хугацаанд хэдэн жилийн цэргийн алба хааж байсан тэр хугацаагаар цэргийн алба хааснаар тооцно.

2. Цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгоход зарим цэргийн албан хаагчийн алба хаасан хугацааг холбогдох хуулийн дагуу нэг жилийг 1 жилээс илүү нэмэгдүүлэн тооцох тохиолдолд цэргийн албан хаагчийн цэргийн алба хаасан хугацааг нэмэгдүүлэн тооцох тухайд:

Цэргийн анги байгууллага нь цэргийн албан хаагчийн цэргийн алба хаасан болон нэмэгдүүлэх хугацааг тооцож, нийт хугацааг тодорхойлон баталгаажуулж өгнө.

Нийгмийн даатгалын байгууллага нь цэргийн албан хаагчийн цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгох нийт хугацааг хөдөлмөрийн дэвтэр, тушаал, шийдвэр, архивын лавлагааг тус тус үндэслэн тэтгэврийг тогтоож олгоно.

3. Цэргийн алба хаасан хугацаанд холбогдох хуульд заасны дагуу 1 жилийг 1 жил 2 сар, 3 сараар гэх мэт тооцож нэмэгдүүлдэг хугацааг оруулан тооцсон тохиолдолд энэ нэмэгдэлтэй хугацаанаас нэг жилийг 1 жил 6 сараар тооцож нэмэгдүүлэх тухайд:

Монгол улсын “Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай”, “Галын аюулгүй байдлын тухай”, “Цагдаагийн байгууллагын тухай”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай” хууль болон бусад холбогдох хуульд заасан нэмэгдэлтэй жилийг 1 жил 6 сараар иргэний байгууллагад шимтгэл төлснөөр тооцно. 1995 оноос хойш цэргийн байгууллагад ажилласан нэг жилийг иргэний байгууллагад шилжүүлэн тооцохдоо 1 жил 6 сараар дүйцүүлэн уг хугацаанд ногдох тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалын шимтгэлийг тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу ажил олгогчийн төлбөл зохих хувь хэмжээгээр тооцно.

4. Хугацаат цэргийн албыг 1995 оноос өмнө 3 жилийн хугацаагаар, байлдагч, түрүүчээр хаасан иргэн өөр байгууллагад шимтгэл төлж ажиллаагүй, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрээр хөдөлмөрийн чадвар алдсан хувь, хугацааг тогтоолгосон бол түүнд тахир дутуугийн тэтгэвэр тогтоох тухайд:

“Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай” хуулийн 3 дугаар зүйлд зааснаар байлдагч, түрүүчээр цэргийн жинхэнэ алба хаасан хугацааг нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаанд оруулан тооцно.

Иймд хугацаат цэргийн албыг 1995 оноос өмнө 3 жилийн хугацаагаар хааснаас өөр ажиллаж, шимтгэл төлсөн хугацаагүй иргэний хувьд уг хугацаат цэргийн алба хаасан хугацааг “Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 14 дүгээр зүйлийн 3, 4-т заасны дагуу тооцоход нийтдээ 3 жил хүрч байвал түүнд “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-ийн 7 дугаар зүйлийн 7.2-т заасны дагуу тахир дутуугийн тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоох ба тухайн хугацааны шимтгэлийг нийгмийн даатгалын санд төлүүлэхгүй.

5. “Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-ийн дагуу цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон цэргийн албан хаагчийн тэтгэвэр авагч нь цэргийн байгууллагад цолтойгоор дахин ажилласан тохиолдолд энэхүү ажилласан хугацааг тэтгэврийн нэмэгдэлд оруулан тооцож, тэтгэврийг өөрчлөн тогтоохгүй тухайд:

“Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-ийн 9 дүгээр зүйлийн 4-т “Цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон боловч 12 сараас доошгүй хугацаанд ажил, хөдөлмөр эрхэлж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн тэтгэвэр авагч хүсэлтээ гаргасан тохиолдолд тэтгэврийн хэмжээг анхны тэтгэвэр тогтоолгосон дундаж цалингаас бодож энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хувиар өөрчлөн тогтооно” гэж заасан тул нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй тухайн иргэний тэтгэврийг энэхүү заалтыг үндэслэн өөрчлөн тогтоохгүй.

Харин анх тэтгэвэр тогтоолгоход баримталсан цэргийн алба хаасан хугацааг нэмэгдүүлэн тэтгэврийг өөрчлөн тогтооно.

6. “Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-ийн дагуу цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгон авч байгаа тэтгэвэр авагч “Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хууль”-д заасны дагуу 1990-2000 онд ажиллаагүй тасарсан жилээ нөхөн тооцуулсан бол тухайн хугацааг цэргийн тэтгэвэр тогтоолгоход баримталсан цэргийн алба хаасан хугацаанд оруулан тооцож, тэтгэврийг өөрчлөн тогтоохгүй тухайд:

“Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-ийн дагуу цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгон авч байгаа тэтгэвэр авагч “Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хууль”-д заасан нөхцөл, болзлыг хангаж, 1990-2000 онд ажиллаагүй тасарсан жилээ нөхөн тооцуулсан бол тухайн хугацааг цэргийн тэтгэвэр тогтоолгоход баримталсан цэргийн алба хаасан хугацаанд оруулан тооцож, тэтгэврийг өөрчлөн тогтоохгүй.

7. “Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-ийн дагуу цэргийн алба хаасны болон хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгон

авч байсан тэтгэвэр авагч нас барсан бол түүний асрамжинд байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүддэд тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоох тухайд:

“Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-ийн 24 дүгээр зүйлд “Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийг тогтоож олгохтой холбогдсон энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн холбогдох заалтаар зохицуулна” гэж заасны дагуу “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-ийн 12 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-д заасныг үндэслэн цэргийн алба хаасны, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгон авч байгаад нас барсан тэтгэвэр авагчийн асрамжинд байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүддэд тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоож олгоно.

8. Цэргийн байгууллагад ажиллаж байгаад ажлаас гарсан цэргийн албан хаагч ажил хөдөлмөр эрхлээгүй (ажилгүй) байхдаа тахир дутуу болсон, нас барсан бол “Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-ийн дагуу хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр, хөдөлмөрийн чадваргүй гэр бүлийн гишүүддэд тэжээгчээ алдсаны тэтгэврийг тогтоон олгохгүй байх тухайд:

“Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-ийн үйлчлэх хүрээнд цэргийн байгууллагад ажиллаж байгаад ажлаас гарсан иргэн хамаарахгүй тул цэргийн байгууллагад тодорхой хугацаанд ажиллаж байгаад ажлаас гарсан цэргийн албан хаагч цаашид ямар нэг байгууллагад ажиллаагүй (ажилгүй) байх үедээ тахир дутуу болсон, нас барсан бол “Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-ийн дагуу хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр, хөдөлмөрийн чадваргүй гэр бүлийн гишүүддэд тэжээгчээ алдсаны тэтгэврийг тогтоон олгохгүй.

9. 2010 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр хүртэл хугацаанд нийгмийн даатгалын сангаас олгох энгийн өндөр насны тэтгэвэр тогтоолгоходоо цэргийн байгууллагад ажилласан жилээ шимтгэл төлсөн хугацаанд оруулан тооцуулсан иргэдийн цэргийн алба хаасан нэг жилийг 1 жил 6 сараар нэмэгдүүлэн шимтгэл тооцсон хугацааг өөрчлөхгүй тухайд:

“Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль”-ийг 2010 оны 09 дүгээр сарын 16-ны өдрөөс болон түүнээс хойш өндөр насны тэтгэвэр шинээр тогтоолгох хүсэлт гаргасан иргэдийн цэргийн байгууллагад ажилласан нэг жилийг 1 жил 6 сараар иргэний байгууллагад шимтгэл төлснөөр тооцож, “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-д заасан болзول, нөхцөлийг хангасан тохиолдолд түүнд өндөр насны тэтгэвэр тогтоож болно. Иймд 2010 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр хүртэл хугацаанд цэргийн байгууллагад алба хаасан жил болон энгийн байгууллагад шимтгэл төлсөн хугацаагаа нэгтгэн тооцуулж, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон иргэдийн хувьд цэргийн алба хаасан нэг жилийг 1 жил 6 сараар нэмэгдүүлэн шимтгэл төлсөн хугацааг өөрчлөхгүй.

10. Цэргийн алба хаасны тэтгэврийг бүрэн болон хувь тэнцүүлэн анх тогтоолгосон боловч цэргийн алба хаасан болон нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцуулж “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-д заасан нөхцөл, болзлын дагуу өндөр насны тэтгэврийг сонгон тогтоолгосон иргэд цэргийн алба хаасны тэтгэврээ буцаан сонгож болох тухайд:

Монгол Улсын Дээд Шүүхийн 2008 оны 47 дугаар тогтоолын 1.3.-т “... уг сонголтыг “зөвхөн нэг удаа” хийнэ гэдэг нь тухайн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ, нөхцөл,

эрх зүйн үр дагавар өөрчлөгдөөгүй байхад өөрийн хүсэлтээр урьд хийсэн сонголтоо даатгуулагч өөрчлөх эрхгүй байхыг хэлэх бөгөөд энэ нь тодорхой цаг хугацааны дараа даатгуулагчаас шалтгаалахгүй үндэслэлээр нөхцөл байдал өөрчлөгдсөн тохиолдолд сонголт хийх даатгуулагчийн эрхийг хязгаарлахгүй” гэж заасныг үндэслэн тухайн иргэний өндөр насын тэтгэврийг өөрчлөн өмнө авч байсан цэргийн алба хаасны бүрэн болон цэргийн алба хаасан хугацаагаар нь цэргийн хувь тэнцүүлсэн тэтгэвэр тогтоож болно.

“Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-д болон “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-д заасан нөхцөл, болзлыг зэрэг хангасан тохиолдолд цэргийн алба хаасны болон энгийн өндөр насын тэтгэврийг “Тэтгэвэр тогтоолтын хуудас”-аар тус тусад нь тогтоож, нэгтгэн олгоно.

Энэ тохиолдолд тэтгэвэр авагчийн нэр дээр тэтгэврийн нэг хувийн хэрэг нээж, холбогдох баримт материал, “Тэтгэвэр тогтоолтын хуудас”-ыг хавсаргаж баталгаажуулна.

Дээрх хоёр тэтгэврийг тус тусад нь кодлож тухайн тэтгэвэр авагчийн нэр дээр мэдээллийн санд оруулна. Харин энэ тохиолдолд тэтгэврийн нэг дэвтэр нээх бөгөөд тэтгэвэр тогтоолгоход баримталсан дундаж цалин (.../...), цэргийн алба хаасан болон шимтгэл төлсөн жил (.../...), сарын олговол зохих тэтгэвэр (.../...) төгрөг гэх зэргээр тэтгэврийн дэвтэрт бичнэ.

Тухайлбал, цэргийн алба 15 жил хаасан, иргэний байгууллагад 17 жил шимтгэл төлсөн гэвэл (15/17) гэж, цэргийн алба хаасны тэтгэвэр бодоход баримталсан дундаж цалин 300 000 ₮, өндөр насын тэтгэвэр тогтооход баримталсан дундаж цалин 200 000 ₮ гэвэл (300000/200000) гэж, цэргийн алба хаасны сарын тэтгэврийн хэмжээ 240 000 ₮, өндөр насын сарын тэтгэврийн 172 200 ₮ гэвэл (240 000 / 172 200) гэж тус тус тэмдэглэнэ.

Цэргийн алба хаасны бүрэн болон хувь тэнцүүлсэн тэтгэвэр буцаан тогтоохдоо “Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-ийн 9 дүгээр зүйлийн 1, 2-т заасан хувь хэмжээ (80 хувь), (1.5 хувь)-гээр бодно.

Санамж1: Энгийн өндөр насын тэтгэврийг тогтоохдоо иргэний байгууллагад шимтгэл төлж, ажилласан сүүлийн 20 жилийн доторхи дараалсан 5 жилийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын тодорхойлолтыг үндэслэнэ.

Санамж2: Тэтгэвэр авагч тэтгэвэр тогтоолгосны дараа нэгээс дээш жил иргэний байгууллагад ажиллан шимтгэл төлсөн бол уг хугацааг энгийн байгууллагад шимтгэл төлсөн хугацаанд, харин цэргийн байгууллагад ажилласан бол цэргийн алба хаасан хугацаанд тус тус оруулан тооцно.

Санамж3: Цэргийн алба хаасны бүрэн болон хувь тэнцүүлсэн тэтгэвэр буцаан тогтоохдоо тухайн иргэнээр өргөдөл бичүүлэн авч тэтгэврийн хувийн хэрэгт хадгална.

11. “Иргэний цэргийн үүргийн болон цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн 2 дугаар зүйлд 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан 1 жилийг нэг жил 4 сараар нэмэгдүүлэн тооцохыг 1997 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн мөрдөх тухайд:

1997 оны 10 дугаар сарын 23-ний өдрийн “Иргэний цэргийн үүргийн болон цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн 2 дугаар зүйлд 28 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг “Тайван цагт нисэх цагийн нормоо биелүүлсэн байлдааны сөнөөгч онгоц, байлдааны нисдэг тэрэгний нисэх бүрэлдэхүүн, хилийн суман, хороонд болон тэдэнтэй адил нөхцөлд байрлаж байгаа радио-техникийн салбарын офицер, ахлагчийн алба хааж байгаа нэг жилийг 1 жил 4 сард дүйцүүлэн тооцно.” гэж өөрчлөн, мөн хуулийн 5 дугаар зүйлд “Энэ хуулийг буцаан хэрэглэхгүй” гэж заасан тул 1997 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн мөрдөнө.

12. Цэргийн алба хаасны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгосон тэтгэвэр авагч нь 10-аас дээш жил энгийн байгууллагад шимтгэл төлж ажилласан, өндөр насын тэтгэвэр тогтоолгох насын болзол хангасан тохиолдолд түүнд нийгмийн даатгалын сангаас олгох өндөр насын тэтгэврийг тогтоож болох тухайд:

Цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосноос хойш энгийн байгууллагад шимтгэл төлж 10-аас дээш жил шимтгэл төлж ажилласан мөн цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгохос өмнө энгийн байгууллагад мөн хугацаа /10 жил/-наас дээш жил ажиллаж, “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-д заасан шимтгэл төлж ажиллавал зохих хугацаа, насын болзлыг хангаж байвал түүнд цэргийн алба хаасны тэтгэврийн зэрэгцээгээр өндөр насын тэтгэврийг бүрэн болон хувь тэнцүүлэн тогтоон олгож болно. Энэ тохиолдолд цэргийн алба хаасны тэтгэврийн хэмжээ нь шимтгэл төлж ажилласан хугацааны 1.5 хувийн нэмэгдлийн дүнгээр хасагдаж тогтоогдоно.

13. Иргэний 1995 оноос хойш цэргийн алба хаасан хугацаанд ногдох тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалын шимтгэлийг санд нэг удаа төлүүлсний дараа уг иргэн нь шимтгэл төлөгдсөн онуудын цалингаар буюу цэргийн алба хааж байсан 5 жилийн цалингийн дунджаар өндөр насын тэтгэвэр тогтоолгож болох тухайд:

Тухайн иргэний тэтгэвэр тогтоолгохоор сонгосон 5 жилийн цалин, хөдөлмөрийн хөлс, орлого нь “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-ийн 22 дугаар зүйлд заасан шимтгэл төлсөн сүүлийн 20 жил дотор багтаж байгаа бол уг 5 жилийн цалин, хөдөлмөрийн хөлс, орлогын дунджаас өндөр насын тэтгэвэр тогтоож болно.

14. Цэргийн алба хаасны тэтгэвэр авагч нь 60 /55/ наасанд хүрээд “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-д заасны дагуу өндөр насын тэтгэвэр болгон өөрчлөн тогтоолгох тохиолдолд цэргийн тэтгэвэр тогтоолгосноос хойш шимтгэл төлж ажилласан дараалсан 5 жилийн цалингийн дунджаар тэтгэвэр тогтоолгож болох тухайд:

“Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-ийн дагуу тогтоосон цэргийн тэтгэврийн харилцаа нь өөрчлөгдөж, түүнд “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-д заасан болзол, журмын дагуу шинээр өндөр насын тэтгэвэр тогтоох үндэслэл бий болж байгаа тул тухайн иргэний өндөр насын тэтгэврийг цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосноос хойш шимтгэл төлсөн дараалсан 5 жилийн хөдөлмөрийн хөлс, орлогын дунджаас тогтоож болно.

15. Иргэний 1995 оноос хойш цэргийн алба хаасан хугацаанд ногдох тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалын шимтгэлтэй тэнцэх хэмжээний хөрөнгийг зохих байгууллагаас нийгмийн даатгалын санд шилжүүлсний дараа тухайн иргэнд өндөр насын тэтгэвэр тогтоох, эсвэл өргөдлийг нийгмийн даатгалын хэлтэс /байцаагч/ хүлээн авсан өдрөөс тогтоох тухайд:

Нийгмийн даатгалын хэлтэс /байцаагч/ нь тухайн иргэний тэтгэвэр тогтоолгох тухай өргөдөл, баримт материалыг 1995 оноос хойш цэргийн алба хаасан хугацаанд ногдох шимтгэлийг шилжүүлэх тухай хүсэлт, тооцоо, баримттай хамт хүлээн авсны дараа шимтгэл төлүүлэх асуудлыг нэхэмжилсэн бол уг шимтгэл хэдэн сарын дараа санд төлөгдсөнийг харгалзахгүйгээр түүний тэтгэврийг өргөдөл, тэтгэвэр тогтоох материалыг анх шалгаж хүлээн авсан өдрөөс эхлэн тогтооно.

Харин нийгмийн даатгалын хэлтэс нь тухайн иргэний 1995 оноос хойш цэргийн алба хаасан хугацаанд ногдох шимтгэлийг шилжүүлэн авах тухай хүсэлт, баримтыг хүлээн авч холбогдох газарт нэхэмжлэл, баримтыг хүргүүлсний дараа түүний өндөр насын тэтгэвэр тогтоолгох тухай өргөдөл, баримтыг хүлээн авсан бол тэтгэврийг баримт материал хүлээн авсан өдрөөс эхлэн тогтооно.

16. Цэргийн алба хаасан хугацааны шимтгэл ногдуулах тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ гэдэг нь шимтгэл төлүүлэхээр хүсэлт гаргах үеийн мөрдөж буй хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй адил байх тухайд:

Монгол улсын Засгийн газрын 2011 оны 9 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтын 3.1-д "...иргэний тэтгэврийн болон тэтгэмжийн шимтгэлийг тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу ажил олгогчийн төлбөл зохих хувь хэмжээгээр тооцон улсын төсвөөс нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлнэ" гэж заасан. Тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ гэдгийг цэргийн албан хаагч, цэргийн алба хаасны тэтгэвэр авагч шимтгэлээ төлүүлэхээр хүсэлт гаргасан үед хүчин төгөлдөр мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гэж ойлгоно. Тухайлбал, 2000-2003 онд цэргийн байгууллагад ажиллаж байсан хугацааны шимтгэлээ төлүүлэхээр 2014 оны 2 дугаар сард хүсэлтээ гаргасан бол тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ буюу 192 000 төгрөгөөс тооцож ногдох шимтгэл ($192\ 000 * 7.8\% * 72$ сар) улсын төсвөөс нэхэмжилнэ.

Цэргийн алба хаасан 1 жилийг 1 жил 6 сар иргэний байгууллагад ажиллан шимтгэл төлсөн хугацаанд оруулан тооцох учир 1 жил 6 сарын шимтгэлийг тооцон нэхэмжилнэ.

17. Цэргийн албан хаагч нь нэг сараас дээш хугацаагаар хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдаж эмнэлгийн хуудсаар тэтгэмж авсан тохиолдолд тухайн албан хаагчийн цалингийн бүрэлдэхүүнд эмнэлгийн хуудсаар бодож олгосон тэтгэмжийн мөнгө орохгүй болон тэтгэмж авсан хугацаанд түүний эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг ямар орлогоос 2.0 хувиар тооцож төлүүлэх тухайд:

"Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль"-ийн 7 дугаар зүйлийн 1-д зааснаар цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийг тогтооход баримтлах орлогын бүрэлдэхүүнийг тодорхойлно. Иймээс нэг сараас дээш хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдаж эмнэлгийн хуудсаар авсан тэтгэмж нь тэтгэвэр, тэтгэмж тогтоох орлогын бүрэлдхүүнд хамаарахгүй. Иймээс 1 сараас дээш хугацаагаар хөдөлмөрийн чадвараа түр алдсан цэргийн албан хаагчийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажил олгогчийн төлөх буюу 2.0 хувиар тооцож цэргийн анги, байгууллага нь эрүүл мэндийн даатгалын санд төлнө.

18. Эх (цэргийн албан хаагч)-эд жирэмсний, амаржсаны тэтгэмжийг 4 сарын хугацаанд олгосон тохиолдолд уг тэтгэмжид эрүүл мэндийн даатгалын шимтгэл ногдуулахгүй болон тэтгэмж авсан хугацааны ЭМД-ын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс 2.0 хувиар тооцож, шилжүүлэх тухайд:

Энэ тохиолдолд цэргийн албан хаагч эхэд олгосон жирэмсний, амаржсаны тэтгэмжид эрүүл мэндийн шимтгэл ногдуулахгүй. Тэтгэмж авсан хугацааны эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод

хэмжээнээс ажил олгогч (анги, нэгтгэл)-ийн төлөх буюу 2.0 хувиар тооцож цэргийн анги, байгууллага нь эрүүл мэндийн даатгалын санд төлнө. Иймээс жирэмсний, амаржсаны тэтгэмж авсан хугацаа нь алба хаасан болон шимтгэл төлсөн хугацаанд орж тооцогдоно.

19. Даатгуулагчийн төмөр замын цэрэгжүүлсэн хамгаалалтын албанд ажилласан хугацаанд 1995 оноос өмнө, хойно цэргийн байгууллагад алба хаасан болон хугацаат цэргийн алба хаасан хугацааг оруулан тооцож, нас харгалзахгүйгээр өндөр насын тэтгэвэр тогтоон олгохгүй тухайд:

Төмөр замын цэрэгжүүлсэн албанд ажилласан хугацааг цэргийн алба хаасан жилд оруулж тооцох талаар хууль эрх зүйн зохицуулалт байхгүй тул төмөр замын цэрэгжүүлсэн хамгаалалтын албанд ажилласан хугацаанд 1995 оноос өмнө, хойно цэргийн байгууллагад алба хаасан болон хугацаат цэргийн алба хаасан хугацааг оруулан тооцож, нас харгалзахгүйгээр өндөр насын тэтгэвэр тогтоон олгохгүй.

20. Цэргийн албан хаагчдын хувьд цаг уурын хүнд нөхцөлтэй улсад ажилласан 1 жилийг 1 жил 6 сараар тооцно заалтыг хэрэгжүүлэхдээ нэмэгдэл 6 сарын шимтгэлийг төлүүлэх тухайд:

Цэргийн албан хаагчдын хувьд цаг уурын хүнд нөхцөл бүхий улсад алба хаасан хугацааг цэргийн жинхэнэ алба хаасан хугацаанд оруулан тооцох бөгөөд 1 жилийг 1 жил 6 сараар нэмэгдүүлэн тооцно. Хэрвээ цэргийн алба хаасан дээрх хугацааг иргэний байгууллагад ажилласнаар шилжүүлэн тооцуулах хүсэлт гаргасан үед 1 жил 6 сарын шимтгэлийг улсын төсвөөс нийгмийн даатгалын санд төлөх асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

21. Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь тухайн иргэний 1995 оноос хойш цэргийн алба хаасан хугацаанд ногдох нийгмийн даатгалын шимтгэлийг төлүүлэхээр хандах тухайд:

Аймаг (дүүрэг)-ийн нийгмийн даатгалын хэлтэс нь цэргийн алба хаасан хугацаагаа иргэний байгууллагад ажиллан нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаанд шилжүүлэх хүсэлт гаргасан иргэний холбогдох мэдээллийг гаргаж, нэгтгэн тухай бүрт нь Нийгмийн даатгалын ерөнхий газрын Төлөвлөлт, санхүү бүртгэлийн газарт ирүүлнэ.

Энэхүү мэдээллийн үндэслэл, шимтгэлийн тооцоог Төлөвлөлт, санхүү бүртгэлийн газар нягтлан шалгаж нийгмийн даатгалын санд төлбөл зохих шимтгэлийг улсын төсвөөс нэхэмжлэн авч, холбогдох аймаг (дүүрэг)-ийн нийгмийн даатгалын хэлтсийн зохих сангийн дансанд шилжүүлнэ.